

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл ус суваг ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/11/НА-СТА-ОНА

| | |
|--|---|
| <p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Мөрөн сум 2023 он</p> | <p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn</p> <p>Ньюбаланс аудит ХХК-ийн партнер Б.Лхагвадорж Утас: 99101901 Цахим хаяг: newbalance.lhagvaa@gmail.com audit.gov.mn</p> <p>Аудитор: Л.Наранбаатар Утас: 89110525 Цахим хаяг: naraa_123@yahoo.com</p> |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|-----------|
| 1. Аудитын санал дүгнэлт..... | 3 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 5 |
| 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан..... | 5 |
| 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан | 6 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 7 |
| 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл..... | 8 |
| 3. Аудитын тайлан | 9 |
| 3.1 Ерөнхий зүйл | 9 |
| 3.2 Дотоод хяналт | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 10 |
| 3.4 Материаллаг байдал..... | 10 |
| 4. Санхүүгийн тайлангийн тодруулга | 10 |
| 4.1 Байгууллагын үйл ажиллагаа..... | 10 |
| 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин | 11 |
| 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого | 11 |
| 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 13 |
| 5.1 Шилэн дансны мэдээлэл..... | 13 |
| 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 14 |
| 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал | 14 |
| 8. Аудитын илрүүлэлт..... | 14 |
| 8.1 Залруулсан алдаа..... | 14 |
| 8.2 Төлбөрийн акт..... | 14 |
| 8.3 Албан шаардлага | 14 |
| 8.4 Зөвлөмж | 14 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..... | 15 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|--|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ХӨА | Хөвсгөл аймаг |
| НА | Нотлох аудит |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| ИТХТ | Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |



ХӨВСГӨЛ УС СУВАГ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ П.ЛХАГВАЖАВ ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.15 № 01/270-
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл ус суваг ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хөвсгөл ус суваг ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Урт хугацаат өр төлбөр, дуусаагүй барилга 2,080.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Азийн хөгжлийн банк, аймгийн Засаг даргын тамгын газар, Ус суваг ХХК-ийн дамжуулан зээлдэх гуравласан гэрээний дагуу валютын ханшийн зөрүү 1,649.0 сая төгрөг, ашиглалтын зардал 431.7 сая төгрөгийг тус тус бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Аудитын гол асуудал

Аудитаар хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 74.7 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлэв.

Бусад асуудлын хэсэг

Компанийн гүйцэтгэх захирал ТУЗ-тэй байгуулсан гэрээг хангалттай хэрэгжүүлж ажилласан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу

илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| /төгрөгөөр/ | | | |
|-----------------|---|--------------------------|--------------------------|
| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
| 1 | Хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 205,481,477.45 | 178,807,331.18 |
| 1.1.2 | Дансны авлага | 277,784,824.26 | 183,540,682.78 |
| 1.1.3 | Татвар, НДШ – ийн авлага | 0.00 | 12,150,631.46 |
| 1.1.6 | Бараа материал | 340,242,348.78 | 388,823,784.89 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 823,508,650.49 | 763,322,430.31 |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 4,751,081,064.99 | 5,275,325,597.97 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 3,634,669,034.56 | 3,645,639,113.74 |
| 1.2.9 | Дуусаагүй барилга | 7,394,880,829.25 | 9,475,600,265.45 |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 15,780,630,928.80 | 18,396,564,977.16 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 16,604,139,579.29 | 19,159,887,407.47 |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 62,934,408.60 | 8,870,451.14 |
| 2.1.1.3 | Татварын өр | 16,231,091.52 | 259,843.41 |
| 2.1.1.4 | НДШ - ийн өглөг | 326,223.82 | 35,948,868.73 |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | 544,149,712.46 | 544,149,712.46 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 478,792.00 | 1,114,604.21 |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 624,120,228.40 | 590,343,479.95 |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 9,272,172,410.09 | 11,352,891,846.29 |
| 2.1.2.6 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 9,272,172,410.09 | 11,352,891,846.29 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 9,896,292,638.49 | 11,943,235,326.24 |
| 2.3 | Эздийн өмч | 2,245,880,669.67 | 2,245,880,669.67 |
| 2.3.1 | төрийн | 2,245,880,669.67 | 2,245,880,669.67 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 657,840,694.47 | 657,840,694.47 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 5,321,717,899.70 | 5,831,314,136.04 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | -1,517,592,323.04 | -1,518,383,418.95 |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 6,707,846,940.80 | 7,216,652,081.23 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 16,604,139,579.29 | 19,159,887,407.47 |

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

| /төгрөгөөр/ | | | |
|---------------|---------------------------------|------------------------|------------------------|
| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 2,653,258,764.10 | 3,468,525,226.47 |
| 2 | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 2,415,278,066.70 | 3,238,778,312.51 |
| 3 | Нийт ашиг (алдагдал) | 237,980,697.40 | 229,746,913.96 |
| 4 | Түрээсийн орлого | 0.00 | 0.00 |
| 5 | Хүүний орлого | 0.00 | 0.00 |
| 6 | Ногдол ашгийн орлого | 0.00 | 0.00 |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | 0.00 | 0.00 |
| 8 | Бусад орлого | 0.00 | 0.00 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 0.00 | 0.00 |

| | | | |
|------|---|----------------------|-------------------|
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 188,520,555.99 | 219,376,483.57 |
| 11 | Санхүүгийн зардал | 0.00 | 0.00 |
| 12 | Бусад зардал | 11,639,908.25 | 0.00 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | -17,003,915.68 | -9,775,464.21 |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | 20,816,317.48 | 594,966.18 |
| 19 | Орлогын татварын зардал | 3,245,622.57 | 59,496.62 |
| 20 | Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | 17,570,694.91 | 535,469.56 |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 17,570,694.91 | 535,469.56 |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | 0.00 | 0.00 |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 |
| 23.3 | Бусад олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 24 | Нийт дэлгэрэнгүй орлогын дүн | 17,570,694.91 | 535,469.56 |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---------------|-------------------------------------|------------------|-------------------------------------|---------------------------|--------------------|------------------|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 2,245,880,669.67 | 657,840,694.47 | 5,379,472,310.36 | -1,406,082,792.41 | 6,877,110,882.09 |
| 3 | Залруулсан үлдэгдэл | 2,245,880,669.67 | 657,840,694.47 | 5,379,472,310.36 | -1,406,082,792.41 | 6,877,110,882.09 |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0. | 0. | 0. | 17,570,694.91 | 17,570,694.91 |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | 0. | 0. | -57,754,410.66 | -129,080,225.54 | -186,834,636.2 |
| 7 | Зарласан ногдол ашиг | 0. | 0. | 0. | 0. | 0. |
| 9 | 2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 2,245,880,669.67 | 657,840,694.47 | 5,321,717,899.7 | -1,517,592,323.04 | 6,707,846,940.8 |
| 11 | Залруулсан үлдэгдэл | 2,245,880,669.67 | 657,840,694.47 | 5,321,717,899.7 | -1,517,592,323.04 | 6,707,846,940.8 |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0. | 0. | 0. | 535,469.56 | 535,469.56 |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | 0. | 0. | 509,596,236.34 | -1,326,565.47 | 508,269,670.87 |
| 15 | Зарласан ногдол ашиг | 0. | 0. | 0. | 0. | 0. |
| 17 | 2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 2,245,880,669.67 | 657,840,694.47 | 5,831,314,136.04 | -1,518,383,418.95 | 7,216,652,081.23 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн | 3,148,921,521.05 | 4,071,942,675.16 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 3,096,732,311.03 | 3,877,543,787.41 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | 0.00 | 0.00 |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 0.00 | 0.00 |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | 0.00 | 0.00 |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | 0.00 | 0.00 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 52,189,210.02 | 194,398,887.75 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 2,943,073,096.68 | 3,753,683,824.51 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 1,096,704,782.16 | 1,381,818,922.38 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 322,149,344.27 | 347,684,399.94 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 560,199,924.00 | 377,626,675.58 |
| 1.2.4 | Ашиглалтын зардал төлсөн | 200,855,791.87 | 650,666,471.35 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 128,697,693.00 | 236,941,418.10 |
| 1.2.6 | Хүүний төлбөрт төлсөн | 0.00 | 0.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 390,195,530.39 | 411,591,951.60 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 7,689,820.00 | 6,451,150.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 236,580,210.99 | 340,902,835.56 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 205,848,424.37 | 318,258,850.65 |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн | 0.00 | 0.00 |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.2 | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.3 | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.4 | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 0.00 | 0.00 |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.7 | Хүлээн авсан ногдол ашиг | 0.00 | 0.00 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн | 87,947,074.00 | 344,932,996.92 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 87,947,074.00 | 325,132,996.92 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 19,800,000.00 |
| 2.2.3 | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| 2.2.4 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| 2.2.5 | Бусад олгосон зээл болон урьдчилгаа | 0.00 | 0.00 |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | -87,947,074.00 | -344,932,996.92 |
| 3 | Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн | 0.00 | 0.00 |

| | | | |
|------------|---|-----------------------|-----------------------|
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0.00 | 0.00 |
| 3.1.2 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0.00 | 0.00 |
| 3.1.3 | Төрөл бүрийн хандив | 0.00 | 0.00 |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн | 0.00 | 0.00 |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 0.00 | 0.00 |
| 3.2.2 | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | 0.00 | 0.00 |
| 3.2.3 | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | 0.00 | 0.00 |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | 0.00 | 0.00 |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 0.00 | 0.00 |
| 4 | Валютын ханшийн зөрүү | 0.00 | 0.00 |
| 4.1 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 117,901,350.37 | -26,674,146.27 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 87,580,127.08 | 205,481,477.45 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 205,481,477.45 | 178,807,331.18 |

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

мян. төгрөг

| № | Эдийн засгийн ангилал | 2021 оны гүйцэтгэл | Тайлант оны | | | |
|----------|--|---------------------|---------------------|---------------------|-------------------|-------------|
| | | | Батлагдсан төсөв | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| 1 | НИЙТ ОРЛОГО | 2,653,258.76 | 3,561,984.80 | 3,468,525.20 | 93,459.60 | 97.4 |
| 1.1 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 280,727.27 | 446,168.10 | 446,168.10 | 0.00 | 100 |
| 1.2 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 2,372,531.49 | 3,115,816.70 | 3,022,357.10 | 93,459.60 | 97.0 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА | 2,603,798.60 | 3,574,230.10 | 3,467,930.30 | 106,299.80 | 97.0 |
| 2.1 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,268,136.60 | 1,648,330.00 | 1,620,275.70 | 28,054.30 | 98.3 |
| 2.2 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 166,869.50 | 222,034.50 | 200,461.40 | 21,573.10 | 90.3 |
| 2.3 | Албан томилолт | 1,350.50 | 9,061.50 | 13,394.50 | -4,333.00 | 147 |
| 2.4 | Шуудан холбоо, хэвлэл захиалга | 7,984.70 | 9,875.10 | 9,729.90 | 145.20 | 98.5 |
| 2.5 | Бичиг хэрэг | 9,091.20 | 6,979.20 | 6,892.30 | 86.90 | 98.8 |
| 2.6 | Зар сурталчилгаа | 4,204.00 | 1,440.00 | 2,449.60 | -1,009.60 | 170 |
| 2.7 | Хөдлмөр хамгаалал | 12,707.40 | 30,494.50 | 21,669.80 | 8,824.70 | 71.1 |
| 2.8 | Нормын сүү | 10,008.90 | 27,284.20 | 12,154.50 | 15,129.70 | 44.5 |
| 2.9 | ХХХувцас хэрэгсэл /өвөл, зуны/ | 16,316.90 | 41,000.00 | 29,946.40 | 11,053.60 | 73.0 |
| 2.1 | Газар ус ашигласны төлбөр | 4,517.40 | 4,500.00 | 494.00 | 4,006.00 | 11.0 |
| 2.11 | Түлш шатахуун | 89,919.80 | 177,171.30 | 162,047.00 | 15,124.30 | 91.5 |
| 2.12 | Бүх төрлийн | | 5,500.00 | 5,500.00 | 0.00 | 100 |

| | | | | | | |
|------|-------------------------------------|------------|------------|------------|------------|------|
| | даатгалууд | 5,318.00 | | | | |
| 2.13 | Сургалт | 1,405.80 | 23,150.00 | 22,181.70 | 968.30 | 95.8 |
| 2.14 | Үндсэн хөрөнгийн элэгдэл | 219,389.80 | 390,590.80 | 320,454.20 | 70,136.60 | 82.0 |
| 2.15 | Болзошгүй гамшиг | 5,000.00 | 5,000.00 | 3,990.10 | 1,009.90 | 79.8 |
| 2.16 | Ариутгал цэвэрлэгээ | 14,159.50 | 21,566.50 | 12,105.20 | 9,461.30 | 56.1 |
| 2.17 | Шинжилгээ | 1,402.30 | 6,028.00 | 3,625.90 | 2,402.10 | 60.2 |
| 2.18 | Цэвэрлэх байгууламжийн химийн бодис | - | 10139.6 | 4417.8 | 5,721.80 | 43.6 |
| 2.19 | Засвар үйлчилгээний зардал | 123,754.70 | 92,201.20 | 152,838.20 | -60,637.00 | 165 |
| 2.2 | Цахилгаан | 176,048.70 | 218,473.30 | 238,226.10 | -19,752.80 | 109 |
| 2.21 | Халаалт | 21,429.00 | 47,656.80 | 42,084.40 | 5,572.40 | 88.3 |
| 2.22 | Түлээ | 23,324.60 | 29,950.00 | 33,394.90 | -3,444.90 | 111 |
| 2.23 | Нүүрс | 197,961.30 | 301,135.60 | 282,357.00 | 18,778.60 | 93.8 |
| 2.24 | НСАХ шагнал | 15,537.00 | 47,315.00 | 60,886.70 | -13,571.70 | 128 |
| 2.25 | Жолоочийн хариуцлагын даатгал | 1,152.90 | 970.90 | 951.20 | 19.70 | 98.0 |
| 2.26 | Үл хөдлөх хөрөнгийн татвар | 9,155.50 | 16,416.00 | 15,719.40 | 696.60 | 95.8 |
| 2.27 | Тээврийн хэрэгслийн татвар | 240.90 | 1,242.10 | 689.4 | 552.70 | 55.5 |
| 2.28 | Газрын төлбөр | 8,894.40 | 11,121.90 | 12,434.60 | -1,312.70 | 111 |
| 2.29 | Найдваргүй авлагын зардал | 54,869.30 | 0.00 | 0.00 | 0.00 | |
| 2.3 | Гадны байгууллагын хөлс | 15,199.60 | 39,982.30 | 41,600.80 | -1,618.50 | 104 |
| 2.31 | ТУЗ-ын зардал | 36,018.50 | 38,229.20 | 38,127.30 | 101.90 | 99.7 |
| 2.32 | Бусад зардал | 82,429.90 | 89,390.60 | 96,830.30 | -7,439.70 | 108 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Хөвсгөл ус суваг” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад өглөг, төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүд болон шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой хүргүүлсэн албан шаардлагыг тусгасан болно.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ний ахлах аудитор Л.Наранбаатар гүйцэтгэж, хяналтыг Ньюбаланс аудит ХХК-ийн захирал Б.Лхагвадорж анхан шатанд хянаж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөвсгөл ус суваг ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Ньюбаланс аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн 29 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ. Дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын нэгжээс болон ТУЗ-ын аудитын хороо хэрэгжүүлэх ёстой, тайлант онд дотоод аудитыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Хөвсгөл ус суваг” ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дүн болох 3,458.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 69.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 55.3 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн шатанд дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Тус компани нь 100 хувь орон нутгийн өмчит компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэрэгжүүлнэ. Компанийн дүрэм нь Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн 105 дугаар тогтоолоор батлагдсан байна.

Компанийн үндсэн зорилт хэрэглэгчдийн дулааны эрчим хүчээр хангах, гүний усыг олборлон эрүүл ахуйн стандартад тохирсон цэвэр ус түгээх, бохир усыг татан технологийн дагуу зайлуулж цэвэрлэх, хэрэглээний халуун усаар хангах, халуун усны үйлчилгээгээр тогтмол найдвартай хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино. Компани нь энэхүү дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх зорилгоор дор дурдсан үйл ажиллагааг эрхэлнэ.

- Дулаан үйлдвэрлэн түгээх, нийтийн зориулалттай хувийн орон сууцанд амьдардаг айл өрхөд халаалт дулаан, сантехникийн засвар үйлчилгээг дуудлагаар хийх, цэвэр ус олборлон хэрэглэгчдэд хүргэх, халуун ус, бохир ус татан зайлуулах, айл өрх, албан байгууллагын халуун, хүйтэн усыг тогтворжуулах зэрэг түүнд нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх явдал юм.
- Компанийн хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа явуулах тухай шийдвэрийг Төлөөлөн Удирдах Зөвлөл гаргана.
- Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардах үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсний дараа тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.
- Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөн байгуулах, хувьчлах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд компани нь үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Хөвсгөл ус суваг” ХХ нь 2016 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 56 дугаар тогтоолыг үндэслэн байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд “Орон нутгийн өмчийн талаарх иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх: ... 4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Гүйцэтгэх захирлын тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам”-ыг баталж, өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж, мөн Орон нутгийн өмчийн газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг тухай бүр хүргүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Тус компанийн санхүүгийн байдлын, орлого, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| | | | /мян төгрөг/ |
|----------------|----------------|-----------------|--------------|
| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 205,481.50 | 178,807.30 | -26,674.20 |
| Авлага | 277,784.80 | 195,691.30 | -82,093.50 |
| Бараа материал | 340,242.30 | 388,823.80 | 48,581.50 |
| Үндсэн хөрөнгө | 4,751,081.10 | 5,275,325.60 | 524,244.50 |

| | | | |
|---|----------------------|----------------------|---------------------|
| Биет бус хөрөнгө | 3,634,669.00 | 3,645,639.10 | 10,970.10 |
| Дуусаагүй барилга | 7,394,880.80 | 9,475,600.30 | 2,080,719.50 |
| Нийт хөрөнгийн дүн | 16,604,139.50 | 19,159,887.40 | 2,555,747.90 |
| Богино хугацаат өглөг | 624,120.20 | 590,343.50 | -33,776.70 |
| Урт хугацаат өглөг | 9,272,172.40 | 11,352,891.80 | 2,080,719.40 |
| Эздийн өмч | 6,707,846.90 | 7,216,652.10 | 508,805.20 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 16,604,139.50 | 19,159,887.40 | 2,555,747.90 |

Тус компани нь Төрийн банк, Хаан банк, Хас банканд харилцах данстай ба харилцах дансны үлдэгдэл 176.8 сая төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны төрөөс хариуцах цэвэр, бохир усны авлага барагдсантай холбоотой. Мөн 2004-2006 онд үүссэн 3 айл өрхийн 4.4 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхэд хандсан байна. Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 191.2 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 388.8 сая төгрөг болж 48.5 сая төгрөгөөр өссөн нь 2022 онд өөрийн хөрөнгөөр засварлаж 4 ухаалаг худаг ашиглалтад оруулсантай холбоотой дэлгэц, хянах самбар, цахилгааны хаалт, импульсийн тоолуур зэрэг багаж хэрэгсэл нэмэгджээ.

Үндсэн хөрөнгө данс нь 524.2 сая төгрөгөөр нэмэгдсэн ба Азийн хөгжлийн банкны санхүүжүүлэлтээр 365.5 сая төгрөгийн юниварсал трактор-1, бохирын машин-1, Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2022 оны 4 дугаар сарын 12-ны өдрийн А/32 тоот тушаалаар 41.8 сая төгрөгийн дизель генератор 1 ширхгийг, мөн газрын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/93 тоот тушаалаар 31.3 сая төгрөгийн цэвэр бохир усны шугамыг, мөн газрын 2022 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/42 тоот тушаалаар 69.9 сая төгрөгийн 8ширхэг нержийн чайн тус тус үнэ төлбөргүйгээр бүртгэсэн, мөн өөрийн хөрөнгөөр 57.4 сая төгрөгийн барилга байгууламж, 90.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 105.8 сая төгрөгийн усны машин, портер, Тоёото Према автомашин, 50.3 сая төгрөгийн тавилга эд хогшил, 24.3 сая төгрөгийн компьютер, принтер тус тус худалдан авч бүртгэсэн, Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/92 тоот тогтоолоор цаашид ашиглах боломжгүй болсон 164.0 сая төгрөгийн өртөгтэй, 9.7 сая төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг акталсан нь үндсэн хөрөнгө 524.2 сая төгрөгөөр өсөх шалтгаан болжээ. Борлуулалтын программ 18.0 сая төгрөгөөр худалдан авч бүртгэсэн, 7.1 сая төгрөгийн элэгдлийн зардал нэмэгдсэн нь биет бус хөрөнгө 10.9 сая төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна.

Богино хугацаат өр төлбөр 33.7 сая төгрөгөөр буурсан нь сумдад өгөх цэвэр бохир усны төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөр, дуусаагүй барилга 2,080.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Азийн хөгжлийн банк, аймгийн Засаг даргын тамгын газар, Ус суваг ХХК-ийн гурвалсан дамжуулан зээлдэх гэрээний дагуу валютын ханшийн зөрүү 1,649.0 сая төгрөг, тайлант оны ашиглалтын зардал 431.7 сая төгрөгийн тус тус бүртгэлд тусгасантай холбоотой байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Хөвсгөл ус суваг ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор 2022 оны бизнес төлөвлөгөөг баталсан байна. Тус төлөвлөгөөнд 3,328.0 сая

төгрөгийн орлого олж, 3,327.4 сая төгрөгийн зардал гарган 0,6 сая төгрөгийн ашигтай ажиллана гэж тусгажээ.

Хөвсгөл ус суваг ХХК-ийн 2022 оны зорилтот түвшний гүйцэтгэлээр 3,468.5 сая төгрөгийн орлого олж 3,467.9 сая төгрөгийн зардал гарган татвар төлөхийн өмнөх ашиг нь 0.6 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

Хүснэгт 2 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/мян.төг/

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2021 оны гүйцэтгэл | 2022 оны | | |
|---|-----------------------------|----------------|---------------------|---------------------|---------------------|-------------|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
| 1 | Үйлдвэрлэсэн цэвэр бохир ус | м3 | 188,616.00 | 232,716 | 246,950 | 106.1 |
| 2 | Зайлуулсан бохир ус | м3 | 161,117.00 | 244,767 | 244,560 | 99.9 |
| 3 | Гэр хорооллын цэвэр ус | м3 | 82,242.00 | 81,954 | 92,020 | 101.1 |
| 4 | Үйлдвэрлэсэн дулаан | М3 | 52,548.00 | 53,505 | 49,685.0 | 92.8 |
| 5 | Халуун усны үйлчилгээ | хүн | 26,443.00 | 36,526 | 36,518.7 | 99.9 |
| 6 | НИЙТ ОРЛОГО | мян/төг | 2,653,258.80 | 3,573,089.40 | 3,468,525.20 | 97.1 |
| | Үндсэн үйл ажиллагаанаас | мян/төг | 2,372,531.60 | 3,126,921.30 | 3,022,357.10 | 96.7 |
| | Орон нутгийн төсвөөс | мян/төг | 280,727.20 | 446,168.10 | 446,168.10 | 100.0 |
| 5 | НИЙТ ЗАРДАЛ | мян/төг | 2,632,442.50 | 3,574,230.00 | 3,467,930.30 | 97.0 |
| 6 | Татварын өмнөх ашиг | мян/төг | 20,816.30 | -1,140.60 | 594.90 | |
| 7 | Цэвэр ашиг /алдагдал/ | мян/төг | 17570.6 | | 535.40 | |

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар зөвлөмж авсан, тайлант онд Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх 90 мэдээллээс 1 мэдээлэл огт мэдээлээгүй, 29 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Үүнд: Хуулийн (6.2.4.хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт, 6.3.6.хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл, 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр)-ийн 1,137.9 сая төгрөгийн мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлээгүй, хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд дараах зөрчилтэй асуудал илэрч байна. Үүнд:

Бизнес төлөвлөгөөг боловсруулахдаа холбогдох хууль, журмыг баримтлан ажиллаагүйгээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчин нийт 22.6 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хөвсгөл ус суваг ХХК-ийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

Өмнөх аудитаар шилэн дансны тухай хууль болон авлагын талаар өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт 50 хувийн биелэлттэй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Тайлант онд дуусаагүй барилга дансны үлдэгдэл нь 2,080.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Азийн хөгжлийн банк, аймгийн Засаг даргын тамгын газар, Ус суваг ХХК-ийн дамжуулан зээлдэх гуравласан гэрээний дагуу валютын ханшийн зөрүү болон тайлант оны ашиглалтын зардлыг тус тус бүртгэлд тусгасантай холбоотой байна.

2. 2020 оноос хойш дуусаагүй барилга дансанд бүртгэгдсэн цэвэрлэх байгууламжийг барилга байгууламж дансанд тусгаж ажиллаагүй байна. Цэвэрлэх байгууламжийн зохих бичиг баримтыг бүрдүүлж үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж тайлагнах асуудлыг дараагийн аудитаар хянах нь зүйтэй

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,212.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,137.9 сая төгрөгийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар 1 албан шаардлага, 74.7 сая төгрөгийн өглөг болон Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн талаар 3 зөвлөмж өгсөн.

8.1 Залруулсан алдаа

2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар залруулга хийгдээгүй болно.

8.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

8.3 Албан шаардлага

Тус компани нь өмнөх оны аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд 1 мэдээлэл огт мэдээлээгүй, 29 мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн, нийт 1,137.9 сая төгрөгийн зөрчил байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4, 6.3.6, 6.4.4, 6.4.8 дах заалттай тус тус нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бизнес төлөвлөгөөг боловсруулахдаа холбогдох хууль, журмыг баримтлан ажиллаагүйгээс Төрийн хэмнэлтийн хуулийн холбогдох заалтуудыг зөрчин нийт 22.6 сая төгрөгийн зөрчил гаргасан нь Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дах заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бизнес төлөвлөгөөг боловсруулахдаа холбогдох хууль, журмыг баримтлан ажиллах

Илрүүлэлт:

Тайлант оны бизнес төлөвлөгөөгөөр батлагдсан урсгал зардлын задаргаанд хоолны зардал тусгагдаагүй байхад захирлын тушаалаар урсгал засварын ажил гүйцэтгэсэн ажилчдын хоолны зардалд 5.8 сая төгрөг зарцуулсан байна. Энэ нь тус компанийн ТУЗ-ын баталсан "Бизнес төлөвлөгөө" –г мөрдөж ажиллаагүй, Төрийн хэмнэлтийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дах заалттай нийцэхгүй ба "эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТУЗ-өөр баталсан "Бизнес төлөвлөгөө"-ний хүрээнд санхүүжилтийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах.

Илрүүлэлт:

Тайлант онд дансны өглөг 8.9 сая төгрөг, татварын өр 0.2 сая төгрөг, НДШ-ийн өр 35.9 сая төгрөг, ажилчин албан хаагчдад өгөх өглөг 0.5 сая төгрөг, хувь хүмүүст өгөх өглөг 0.6 сая төгрөг нийт 46.1 сая төгрөг төлж барагдуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалттай нийцэхгүй ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дансны өглөг ба төлбөрийн тооцоог хянах, өр төлбөрийг барагдуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Дүн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|--------------------|-------------|---------------|-----------------|---------|--------------------------------------|--|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал |

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
|-----------------------|----------|-----------------|----------|----------|----------|----------|----------|-----------------|----------|---------------------|----------|----------|
| Өглөг барагдуул аагүй | 1 | 46,193.7 | | | | | 1 | 46,193.7 | | 0 | 0 | 0 |
| Дүн | 1 | 46,193.7 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 46,193.7 | 0 | 0 | 0 | 0 |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | /мянган төгрөгөөр/ | | | | | |
|--|-------------|--------------------|--------------------|----------|-----------------|--------------------|----------|-----------------|
| | | | Үүнээс | | | | | |
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Хугацаа хоцроож мэдээлсэн | 29 | 1,137,900.0 | 0 | 0 | 1 | 1,137,900.0 | 0 | 0 |
| Огт мэдээлээгүй | 1 | 0 | 0 | 0 | | | | 0 |
| Дүн | 30 | 1,137,900.0 | 0 | 0 | 1 | 1,137,900.0 | 0 | 0 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн талаар | 2 | 28,499.2 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 28,499.2 |
| Дүн | 2 | 28,499.2 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 28,499.2 |
| Нийт дүн | 32 | 1,166,399.2 | 0 | 0 | 1 | 1,137,900.0 | 2 | 28,499.2 |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ ПАРТНЕР



А.ЭРДЭНЗБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО: 13/15

Л.МАНДАХНАРАН ОГНОО: 11/15

Б.ЛХАГВАДОРЖ ОГНОО: 15/11